




Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 сарын 22-ны өдрийн 04/06 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

Компанийн нэр:	“Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК” ХХК	Баримт бичгийн код:	ТУЗ.Б.001-01
		Хувилбарын дугаар:	01
Баталсан огноо:	2022.12.22	Мөрдөж эхлэх огноо	2022.12.22
Батлав.	 <p>Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ж.САНДАГСҮРЭН</p>	Хуудасны тоо:	5

Баримт бичгийн нэр:

КОМПАНИЙН ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО

Баримтын төрөл:	Дүрэм
Нууцын зэрэглэл:	Дотоод хэрэгцээнд
Зохицуулах үйл ажиллагаа:	Компанийн эрх бүхий албан тушаалтны залгамж халааг төлөвлөх, компанийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг хангах
Хариуцах хороо/дарга, гишүүн:	Нэр дэвшүүлэх хороо, дарга
Хуулбарыг:	ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, Компанийн Гүйцэтгэх удирдлага

Энэхүү баримт нь “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК” ХХК-ийн өмч бөгөөд зөвшөөрөлгүйгээр ашиглах, хуулбарлахыг хориглоно.

АГУУЛГА

НЭГ. ӨӨРЧЛӨЛТИЙН ТЭМДЭГЛЭЛ.....	2
ХОЁР. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	3
ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ.....	3
ДӨРӨВ. БАРИМТ БИЧИГ ХАРИУЦАГЧ.....	3
ТАВ. НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР.....	3
ЗУРГАА. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	3
ДОЛОО. ГЭНЭТИЙН ТОХИОЛДОЛД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ.....	4
НАЙМ. ХЯНАЛТ.....	4

НЭГ. ӨӨРЧЛӨЛТИЙН ТЭМДЭГЛЭЛ

№	Заалт	Өөрчлөлтийн бичилт	Шалтгаан	Баталгаажилт
1				
2				
3				
4				
5				
6				
7				
8				
9				
10				
11				
12				
13				
14				
15				
16				
17				
18				
19				
20				

Энэхүү баримт нь "Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК" ХХК-ийн өмч бөгөөд зөвшөөрөлгүйгээр ашиглах, хуулбарлахыг хориглоно.

ХОЁР. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

2.1. Энэхүү Залгамж халааны бодлого (цаашид “Бодлого” гэх)-ын баримт бичгийн зорилго нь “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн эрх бүхий албан тушаалтны залгамж халааг төлөвлөх, компанийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг хангахад оршино.

2.2. Компанийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, эрх бүхий албан тушаалтны орон тоо гэнэт буюу төлөвлөгдөөгүйгээр өөрчлөгдсөнөөс үүдэн оролцогч талууд хохирохгүй байх нөхцөлийг хангахын тулд эрх бүхий албан тушаалтны залгамж халааг тодорхойлох хүрээнд энэхүү бодлогыг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо (цаашид “Хороо” гэх) нь хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ

3.1. Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, эрх бүхий албан тушаалтан үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

ДӨРӨВ. БАРИМТ БИЧИГ ХАРИУЦАГЧ

4.1. Баримт бичгийг Нэр дэвшүүлэх хорооны дарга хариуцна.

ТАВ. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

5.1. Бодлогын баримт бичигт хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

5.1.1. “эрх бүхий албан тушаалтан” гэж төлөөлөн удирдах зөвлөл (цаашид ТУЗ гэх)-ийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, ерсхий нягтлан бодогч, Санхүүгийн зохицуулах хорооноос заасан бусад албан тушаалтныг;

5.1.2. “гүйцэтгэх удирдлага” гэж Гүйцэтгэх захирлыг ойлгоно.

ЗУРГАА. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

6.1. Хороо нь эрх бүхий албан тушаалд дэвшүүлэх ажилтны ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах ба хэрэгжүүлэх, үнэлж дүгнэх замаар залгамж халааны бодлогыг хэрэгжүүлнэ.

6.2. Хороо нь компанийн эрх бүхий албан тушаалд нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтооно.

6.3. Хороо нь дотоод болон гадаад эх үүсвэрээс эрх бүхий албан тушаалд тохирох нэр дэвшигчийг тодорхойлж, санал болгоно.

6.4. Хорооноос эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг үнэлж, дүгнэлт гаргасны үндсэн дээр улираан нэр дэвшүүлэх, эсхүл чөлөөлөх саналыг гаргана.

6.5. Өндөр насны тэтгэвэрт гарах болон таамаглаж болохуйц сул орон тоонд шаардлага хангасан нэр дэвшигчийг урьдчилан тодорхойлохын тулд Хороо болон гүйцэтгэх удирдлага нь жил бүрийн давтамжтайгаар судалгаа хийнэ.

6.6. Компанийн алсын хараа, эрхэм зорилго, чанарын зорилт, тухайн жилийн бизнес төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг өргөтгөх тохиолдолд шинээр гарч болзошгүй орон тоог Гүйцэтгэх удирдлага Хороонд санал болгож, Хороо нь орон тоог ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

Энэхүү баримт нь “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК” ХХК-ийн өмч бөгөөд зөвшөөрөлгүйгээр ашиглах, хуулбарлахыг хориглоно.

6.7. Гүйцэтгэх удирдлага компанийн ажилтнуудын сургалт, хөгжлийн төлөвлөгөөг гаргах бөгөөд албан тушаал дэвшин ажиллах боломжтой, чадварлаг ажилтнуудыг тодорхойлж, ур чадварыг нь хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

6.8. Компанийн эрх бүхий албан тушаалтны залгамж халааг бэлтгэхэд шаардлагатай сургалт, хөгжлийн журам, төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх бөгөөд хэрэгжилтэд Хороо хяналт тавин ажиллагаа.

ДОЛОО. ГЭНЭТИЙН ТОХИОЛДОЛД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

7.1. Компанийн эрх бүхий албан тушаалтан буюу ТУЗ-ийн дарга, гишүүд, Гүйцэтгэх удирдлагын орон тоо гэнэтийн тохиолдлоор суларсан тохиолдолд Хороо тохиромжтой, томилох боломжтой этгээдийн судалгаа хийн нэр дэвшигчдийг сонгон ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

7.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан буюу компанийн удирдлагын багийн гишүүд, нягтлан бодогч, Санхүүгийн зохицуулах хорооноос заасан бусад албан тушаалтны орон тоо гэнэтийн тохиолдлоор суларсан тохиолдолд Гүйцэтгэх удирдлага тохиромжтой, томилох боломжтой этгээдийг компанийн Удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

7.3. Компанийн Гүйцэтгэх удирдлага урт хугацаанд чөлөө авах, өвчтэй байх тохиолдолд түүнийг орлоо ажиллах этгээдийг Хорооны санал болгосноор ТУЗ -ийн дарга томилно.

НАЙМ. ХЯНАЛТ

8.1. Энэхүү бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд Хороо хяналт тавьж ажиллах ба ТУЗ-өөс бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.

-ооо-